



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 12 сарын 09 өдөр


Дугаар A/166

Улаанбаатар хот

Г Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Нийгмийн даатгалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, Засгийн газрын 2021 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 67 тоот тогтооолоор батлагдсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн 2 дахь хэсгийн 2.16 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчийг сонгон шалгаруулах журам”-ыг нэгдүгээр, “Үнэлгээний хуудас”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дарга /П.Мөнхтүлга/-д үүрэг болгосугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2015 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/55 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Нийгмийн даатгалын өрөнхий газрын  
даргын 2021 оны 12 дугаар сарын  
09.-ны өдрийн A/166 тоот тушаалын  
нэгдүгээр хавсралт

**ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАЛЫН ШИНЖЭЭЧ ЭМЧ,  
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛИЙН ЭМЧИЙГ СОНГОН  
ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Төв болон салбар, орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шинжээч болон төрөлжсөн мэргэжлийн эмчийг сонгон шалгаруулах харилцааг зохицуулахад хуульд өөрөөр заагаагүй бол энэхүү журмыг баримтална.

1.2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын хамтарсан болон дахин магадлалд оролцох, мэргэжлийн зөвлөгөө өгөх, дүгнэлт гаргах, хөндлөнгийн үнэлгээ, судалгаа шинжилгээ хийх чиг үүрэг бүхий мэргэжилтнийг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын “Шинжээч эмч” /цаашид шинжээч эмч гэх/ гэнэ.

1.3. Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцож хамтарсан шийдвэр гаргах, зөвлөмж өгөх, судалгаа шинжилгээ хийх чиг үүрэг бүхий салбар, орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын бүрэлдэхүүнд ажиллах эмчийг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын төрөлжсөн мэргэжлийн эмч /цаашид “Төрөлжсөн мэргэжлийн эмч” гэх/ гэнэ.

1.4. Шинжээч эмч болон төрөлжсөн мэргэжлийн эмчийн сонгон шалгаруулалтыг Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай зэрэг хуулийн хүрээнд зохион байгуулна.

1.5. Шинжээч эмч болон төрөлжсөн мэргэжлийн эмчийг 3 жил тутамд нээлттэй сонгон шалгаруулна. Шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалтыг хугацаанаас өмнө бүрэн болон хэсэгчилсэн байдлаар зохион байгуулж болно.

1.6. Гэрээний үүргээ хангалттай биелүүлж, ёс зүйн болон мэргэжлийн алдаа зөрчил гаргаагүй шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчийг 1 удаа улираан ажиллуулж болно.

1.7. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа шудрага, ил тод, адил тэгш нээлттэй өрсөлдөөний зарчмыг удирдлага болгоно.

1.8. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч болон салбар болон орон нутгийн төрөлжсөн мэргэжлийн эмчтэй эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд оролцох хөдөлмөрийн гэрээг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс болон аймаг (дүүрэг)-ийн Нийгмийн даатгалын хэлтэстэй байгуулж ажиллана.

## **Хоёр. Сонгон шалгаруулах комисс байгуулах**

2.1. Шинжээч эмч, сэтгэцийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчний Эмнэлэг хөдөлмөрийн магадлах салбар комисс /цаашид салбар комисс гэх/-ын төрөлжсөн мэргэжлийн эмчийн сонгон шалгаруулалтыг нийгмийн даатгалын төв байгууллага зохион байгуулна.

2.2. Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс /цаашид орон нутгийн комисс гэх/-ын төрөлжсөн мэргэжлийн эмчийн сонгон шалгаруулалтыг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар, нийгмийн даатгалын хэлтэс хамтран зохион байгуулна.

2.3. Уг журмын 2.1, 2.2-т заасан сонгон шалгаруулах комисс нь 5 хүний бүрэлдэхүүнтэй байна. Шинжээч эмч болон салбар комиссын төрөлжсөн мэргэжлийн эмчийг сонгон шалгаруулах комиссын дарга нь Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дарга, орон нутгийн комиссын төрөлжсөн мэргэжлийн эмчийг сонгон шалгаруулах комиссын дарга нь Нийгмийн даатгалын хэлтсийн дарга байна.

2.4. Сонгон шалгаруулалт зохион байгуулах бүрт сонгон шалгаруулах комиссыг шинээр байгуулна.

### **Гурав. Сонгон шалгаруулалтад нэр дэвшүүлэх, тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг**


3.1. Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөл, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, их, дээд сургууль, мэргэжлийн холбоо, нийгэмлэгүүд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисст ажиллах эмч нарын нэрийг дэвшүүлнэ.

3.2. Сонгон шалгаруулалтад нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Эмчлэх эрхийн лицензтэй;
- Эмчийн мэргэжлийн зэрэгтэй, /шинжээч эмч нь тэргүүлэх ба түүнээс дээш зэрэгтэй байх/;
- Анагаах ухааны магистраас дээш боловсролын зэрэгтэй;
- Багаар ажиллах, үнэлгээ, дүгнэлт өгөх чадвартай, эрүүл мэндийн байгууллагын нэгж хэсгийг удирдаж байсан туршлага бүхий;
- Ёс зүйн зөрчилгүй, гэмт хэрэгт холбогдож байгаагүй, ял шийтгэлгүй;

3.3. Нэр дэвшигч нь дараах баримт бичгийг бүрэн бүрдүүлж, битүүмжлэн сонгон шалгаруулах комисст ирүүлнэ. Үүнд:

- Нэр дэвшигчийн өөрийн хүсэлт;
- Цахим үнэмлэхний хуулбар;
- Анкет (төрийн албан хаагчийн 1-р маягтаар);
- Боловсролын диплом, мэргэжлийн болон мэргэшлийн зэргийн үнэмлэхийг нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- Нэр дэвшүүлсэн байгууллагаас гаргасан ажил байдлын болон мэргэжлийн алдаа, ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй тухай тодорхойлолт;



- Нэр дэвшиүүлсэн байгууллагын санал;
- Нэр дэвшиүүлэх саналыг хэлэлцсэн хурлын тэмдэглэл;

### **Дөрөв. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах**

4.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулалтын баримт бичиг хүлээн авах эцсийн хугацаа болон сонгон шалгаруулалтын баримт бичгийг нээх хугацааг сонгон шалгаруулалтын урилгад тодорхой тусгана.

4.2. Сонгон шалгаруулалтын явцыг дүрс бичлэгээр баталгаажуулна.

4.3. Сонгон шалгаруулах урилгыг материал хүлээж авах эцсийн хугацаанаас 30-аас доошгүй хоногийн өмнө үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн байгууллагын цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

4.4. Сонгон шалгаруулах комиссын нарийн бичгийн дарга нь товлосон хугацаанд сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн баримт бичгийг хүлээн авч, жагсаалт үйлдэн, битүүмжилсэн хэвээр хадгална.

4.5. Шинжээч эмч болон төрөлжсөн мэргэжлийн эмчийн сонгон шалгаруулах комисс нь сонгон шалгаруулалтын нээлтийг зөвхөн заасан газар, товлосон хугацаанд зохион байгуулна.

4.6. Нээлтийн товлосон хугацаа эхлэхээс өмнө сонгон шалгаруулалтын баримт бичгийг буцааж авах тухай хүсэлт ирсэн тохиолдолд битүүмжилсэн хэвээр буцааж олгоно.

4.7. Нээлтийн үед хөтөлсөн тэмдэглэлд сонгон шалгаруулах комиссын гишүүд болон нээхэд байлцсан нийт орлцогчид гарын үсэг зурна. Орлцогчид гарын үсэг зурахгүй байх нь сонгон шалгаруулалтын нээлт хүчингүй болох үндэслэл болохгүй.

4.8. Шинжээч эмч болон салбар, орон нутгийн комиссын төрөлжсөн мэргэжлийн эмчийн сонгон шалгаруулалтыг комиссын гишүүдийн 80-аас доошгүй хувийн иртэй зохион байгуулсан тохиолдолд хүчинтэйд тооцно.


4.9. Шинжээч эмч болон салбар, орон нутгийн комиссын төрөлжсөн мэргэжлийн эмчийн сонгон шалгаруулалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

/ ye

4.9.1. Шинжээч эмч болон төрөлжсөн мэргэжлийн эмчийн сонгон шалгаруулалтад оролцогчийн материал бүрийн битүүмжлэлийг шалган, нээж энэхүү журмын 3.3-т заасан баримт бичиг дутуу тохиолдолд материалыг буцаах;

4.9.2. Шинжээч эмч болон төрөлжсөн мэргэжлийн эмчийг сонгон шалгаруулах комиссын гишүүн бүр саналын эрхтэй оролцох ба тус бүртээ үнэлгээ өгөх;

4.9.3. “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-д заасан ерөнхий шаардлага болон уг журмын 3.3-т заасан шалгаруурыг хавсралтаар батлагдсан “Үнэлгээний хуудас”-аар дүгнэнэ.



4.9.4."Үнэлгээний хуудас"-аар дүгнэхдээ шалгуур тус бүрт "хангасан" "хангаагүй" гэсэн тэмдэглэл хийх ба бүх шалгуурыг хангасан оролцогчийг эхний шалгаруулалтад тэнцсэнд тооцно.

// ye

4.9.5.Эхний шалгаруулалтад тэнцсэн оролцогчтой ярилцлага хийх;

4.9.6.Сонгон шалгаруулах комиссын гишүүд оролцогчоос эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой асуулт асууж, хариулсан байдалд тус бүртээ 1-5 оноогоор дүгнэх;

4.9.7.Сонгон шалгаруулах комиссын нарийн бичгийн дарга нь гишүүдийн үнэлгээг нэгтгэх;


4.9.8.Хамгийн өндөр оноотой үнэлэгдсэн оролцогчийг шалгаруулна.

4.9.9.Сонгон шалгаруулалтын дүнг нэгтгэж, танилцуулга бэлтгэн, дүрс бичлэгийн хамт Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисст хүргүүлэх;

4.10.Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс нь орон нутгийн комиссын төрөлжсөн мэргэжлийн эмчийн болон шинжээч эмчийн сонгон шалгаруулалтын дүнг хянаж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдлагад танилцуулан баталгаажуулна. Шаардлагатай тохиолдолд гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллах ба сонгон шалгаруулалтын дүнг хүчингүй болгох эрхтэй ажиллана.

4.11.Сонгон шалгаруулалт зохион байгуулсан тухай мэдээллийг нийгмийн даатгалын албан ёсны цахим хуудсанд байршуулж, нийтэд мэдээлэх

4.12.Сонгон шалгаруулалтанд оролцогч нь сонгон шалгаруулалтын дүнг хүлээн зөвшөөрөгүй тохиолдолд дүнг нийтэд зарласнаас хойш 14 хоногт багтаан сонгон шалгаруулах комисст бичгээр гомдол гаргаж болно. Гомдлыг 14 хоногт багтаан хянан шийдвэрлээгүй бол шүүхэд хандаж болно.



Нийгмийн даатгалын ерөнхий газрын  
даргын 2021 оны 12.. дугаар сарын  
09.-ны өдрийн 09/16 тоот тушаалын  
хоёрдугаар хавсралт

## ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

..... төрөлжсөн мэргэжлийн эмчийн сонгон шалгаруулалтад оролцогчийн

Овог: ..... Нэр: .....

Үнэлгээ өгсэн комиссын гишүүний нэр: .....

**Зөвхөн сонгон шалгаруулалтын I үед (✓) тэмдэглэгээ хийнэ.**

	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ	
		Хангалттай	Хангалтгүй
<b>Сонгон шалгаруулалтын I үе</b>			
	Мэргэжлийн чиглэл нь сонгон шалгаруулалтын урилгад заасан мэргэжилтэй тохирч	Мэргэжлийн үнэмлэхтэй эсэх	
	Эмчлэх эрхийн зөвшөөрөл	Хүчинтэй эсэх	
	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх		
	Мэргэжлийн зэрэгтэй эсэх	Ахлах	
		Тэргүүлэх*	
		Зөвлөх*	
	Боловсролын зэрэгтэй эсэх	Магистр	
		Доктор*	
		Профессор*	
	Эрүүл мэндийн байгууллагын нэгж хэсгийг удирдаж байсан туршлагатай эсэх	Тасгийн эрхлэгч	
		Эмнэлгийн дарга	
		Зөвлөх эмч	
		Холбооны тэргүүн	


	Ажил байдлын тодорхойлолт болон цахим лавлагааг үндэслэх	Мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргасан эсэх		
		Гэмт хэрэгт холбогдож байсан эсэх		
<b>Тэнцсэн эсэх</b>				
<b>Сонгон шалгаруулалтын II үе</b>				
д/д	Асуулт	Тайлбар	1-5 оноо	
1.	Асуулт-1			
2.	Асуулт-2			
3.	Асуулт-3			
4.	Асуулт-4			
5.	Асуулт-5			

Тайлбар: \* тэмдэгтэй шалгуур үзүүлэлт нь зөвхөн “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын шинжээч эмч”-ийг сонгон шалгаруулахад хамаарна.

Үнэлгээ өгсөн:

Гарын үсэг

гарын үсгийн тайлал



20..... оны ..... сарын .....-ний өдөр